



НИЙСЛЭЛИЙН  
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/18

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, мөн хуулийн 17 дугаар зүйл, 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.3, 47.2, 3, 6, 7 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны A/86 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны A/86 дугаар захирамжаар батлагдсан хөрөнгөөр Нийслэлийн Төр захиргааны авто баазын автомашины засвар үйлчилгээнд зориулж автомашиныг засварын тоног төхөөрөмж худалдан авах тендер зарлаж байгаатай холбогдуулан Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга

Х.Ажрахгүй /Тээвэр, зохицуулалтын хэлтсийн дарга ерөнхий инженер/

Гишүүд

Б.Баярчимэг /Хувийн хэвшил/

Нарийн бичгийн дарга

М.Баянсан /Хувийн хэвшил/

Д.Пүрэвсүрэн /Төрийн байгууллагын ажилтан/

Х.Одончимэг /Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, ерөнхий нябо/

2. Үнэлгээний хороо нь үйл ажиллагаандaa Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгож, үнэлгээний ажлыг чанартай гүйцэтгэн бусад холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллахыг Үнэлгээний хороо /Х.Ажрахгүй/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.НАРАНБААТАР

